




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт




ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 6%,
Инфляци: 2022 онд: 8.2%,
Урсгал тэнцэл: 2022 онд: -10.2%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: 7.5%
Инфляци: 2021 онд: 7.3%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: -8.5%- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 8-р сарын байдлаар 899.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 11.9 хувиар өссөн бол, зарлага 29.7 хувиар буурч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 899.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 13.6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 32.67 төгрөгөөр өсжээ.

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 336 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 32.67 төгрөгөөр өсөж 3185.70 төгрөг болов. 8-р сард гадаад валютын нөөц 2.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -6.36 оны эхнээс 38.26 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 39.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцын түвшин 14.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 8-р сарын байдлаар өмнөх сараас 0.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар, оны эхнээс 9.7 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 21.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 3 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 29.4 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 18.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 2156 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны наймдугаар сард нийт барааны эргэлт 13.356 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 32.2 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 37.8 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 34.1 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 2156 сая ам.долларын ашигтай гарав.



8-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 8-р сард өмнөх сараас 2.3 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 14.6 хувиар тус тус өсч 22.7 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2513 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 26.1 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 10 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11% байна.

САРЫН ОНЦЛОХ

ИПОТЕКИЙН 355 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙГ 4.5 МЯНГАН ӨРХӨД ОЛГОВ.

- Монголбанк болон бусад банкны эх үүсвэрээр энэ оны эхний 7 сард 355 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 4.5 мянган өрхөд олгоод байна. Мөн 2022 оны 8 дугаар сард 71.7 тэрбум төгрөгийн зээл олгохыг төв банк мэдээллээ. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2021 онд нийт 1 их наяд төгрөгийн зээлийг 13.5 мянган өрхөд олгосон. Цар тахлын хуулийн дагуу хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр 2020 оны 4 дүгээр сараас 2022 оныг дуустал 5 удаа хойшлуулсан. Сүүлийн буюу 5 дахь удаагийн төлбөр хойшлуулалтаар 3.4 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63,171 зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлууллаа.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО 0.2-5 ХУВИАР БАГАСЖЭЭ

- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны энэ оны 2 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж орлого, оны үнээр 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 244.6 (15.9 хувь) мянга, өмнөх улирлынхаас 1.7 (0.1 хувь) мянган төгрөгөөр нэмэгджээ. Харин нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит орлого мөн улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 (0.2 хувь) мянга, өмнөх улирлынхаас 60.2 (5 хувь) мянган төгрөгөөр багаслаа. Өрхүүдийг мөнгөн орлогоор нь бүлэглэвэл энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 300 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 2.4 мянгаар, 300-500 мянган төгрөгийн орлоготой өрх 12.4 мянгаар, 500-700 мянган төгрөгийн орлоготой өрх 12.4 мянгаар, 700- 900 мянган төгрөгийн орлоготой өрх 25.8 мянгаар, 900 мянгаас 1.1 сая төгрөгийн орлоготой өрх 0.2 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрх 16.6 мянгаар багассан аж. Харин 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрх 13.5 мянгаар, 2.1-3 сая төгрөгийн орлоготой өрх 34.5 мянгаар, 3 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 38.3 мянгаар нэмэгдэв.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 8-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 8-р сар 2022 он, Монголбанк
3. www.1212.mn, www.monqolbank.mn, www.montsame.mn